



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/КЭД

Улаанбаатар хот

**Нийслэлийн Агаарын бохирдолтой
тэмцэх газрын хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,757,408.0 /Зургаан сая долоон зуун тавин долоон мянга дөрвөн зуун найман/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар /Х.Галымбек/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар /Х.Галымбек/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



1500001578

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны .12. дугаар сарын .11. өдрийн 4/520 тоот тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	эх үүсвэр
1	Дээжний хийн халаагч хошуу	Heating pipe B-60HP	A06023	2019	ш	2	3,378,704	6,757,408	ЖАЙКА	Төсөл
Тавилга, эд хогшлын дүн						2		6,757,408		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн						2		6,757,408		